



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/108

Өлгий

“ Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны”
төлөвлөгөөг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а” заалт, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцэст нэгтгэж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Засаг даргын Тамгын газар /Х.Тилеген/-т даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /Х.Тилеген/-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



АТ ҮЙЛМХАН

00000256

Аймгийн засаг даргын ... оны
 ... сарын ... өдрийн ... Стогт
 захирамжийн дэвсгэрт



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2017.03.01

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	№	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хариуцах байгууллага
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
1.(4.1.1.1). Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	1	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг(ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох	Тухай бүрд	Төрийн албаны салбар зөвлөл, Төрийн захиргааны удирдалгын хэлтэс
	2	Төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох	Тухай бүрд	Төрийн албаны салбар зөвлөл
2.(4.1.1.2).Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	1	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэдэг байх	Тухай бүрд	Төрийн албаны салбар зөвлөл

3.(4.1.1.7).Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	1	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	Жилд	Төрийн захиргааны удирдалгын хэлэс
4.(4.1.1.9).Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах	1	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох ажлыг шийдвэрлэх боломжийг судлах	Жилд	Төрийн захиргааны удирдалгын хэлтэс,Төрийн албаны салбар зөвлөл
5.(4.1.1.10).Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	1	Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах нийтийн албаны сургалтын институт байгуулах болмжийг бий болгох	Жилд	Төрийн захиргааны удирдалгын хэлтэс
	2	Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулах	Жилд	Төрийн албаны салбар зөвлөл
	3	Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах	Жилд	Хууль эрх зүйн хэлтэс
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
6.(4.1.2.1).Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	1	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах	Хагас жид багтаан	Төрийн захиргааны удирдалгын хэлтэс
7.(4.1.2.2). Зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад	1	Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх боломжтой эсэх талаар судалгаа гаргах	Жилд	Хууль эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс,

шилжүүлэх	2	Тухайн байгууллагаас олгож байгаа зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, зөвшөөрөл эрхлэх дүгнэлт олгох/ гм бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтын гаргах, цахим хуудасандаа байршуулсан байх	Турай бүрт	Стандарт, хэмжил зүйг хэлтэс, ОБХ, МХГ, /газар/ сумдын Засаг дарга
	3	Тухайн зөвшөөрөл, гэрчилгээ эзэмшигчийн нэр, хаяг, үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	Тухай бүрт	Хууль эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Стандарт, хэмжил зүйг хэлтэс, сумдын Засаг дарга
8.(4.1.2.4). эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтыг боловсронгуй болгох	1	Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	Жилийн турш	Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс
9.(4.1.2.7).Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	1	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх	Жилд	Төрийн захиргааны удирдалгын хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр,ха

				ламжгийн үйлчилгээний хэлтэс, Аймгийн нэгдсэн эмнлэг, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
	2	Төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, үйлчилгээг иргэн үнлэх боломжийг бүрдүүлэх.	Хагас жилд багатаан	Төрийн захиргааны удирдалгын хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Аймгийн нэгдсэн эмнлэг, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
<p>Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр</p>				

10.(4.1.3.1). Улсын төсөв болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдалгын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх	1	Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох	Тухай бүрд	Төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлвөлөлтийн хэлтэс
	2	Хувь хүн, хуулийн этгээдээс төсвийн байгууллагад өгсөн хандив, тусламж гэх мэт төсвийн бус орлого, түүнийг олон нийтэд мэдээлэх	Тухай бүрд	Төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлвөлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар
	3	18.Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод болгох 19.Тухайн жилийн төсөв /1-р сарын 10-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/, дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/-ийг цахим хуудсанд байршуулах	Тухай бүрд	Төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлвөлөлтийн хэлтэс
	4	20.Жилийн эцсийн санхүүгийн тайланг болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах		
	5	21.Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээлэх		

	6	22.Концессын зүйлийн жагсаалт баталсан ИТХ-ын шийдвэрийг цахим хуудсанд байршуулах /нэмэлт өөрчлөлт орсон бол батлагдсанаас хойш ажлын 14 хоногийн дотор цахим хуудсанд байршуулах		
11.(4.1.3.4). Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах	1	Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах	Төсвийн тухай хуульд заасан хугацаанд	Төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлвөлөлтийн хэлтэс, Сумдын Засаг дарга нар
	2	Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлэгийн талаар Засгийн газрын www.iltod.mn , www.shilendans.mn цахм хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэх	Тухай бүрд	Төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлвөлөлтийн хэлтэс, Сумдын Засаг дарга нар
Дөрөв. Худалдан авах ажиллагааг үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				

12.(4.1.4.1). Тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	1	Худалдан авах үйл ажиллагааны бүх тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын зарыг www.bayan-olqii.gov.mn , www.bayan-olqii.khural.mn цахим хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүрд зарлан байршуулах	Тухай бүрт	Орон нутгийн өмчийн газар
	2	Орон нутгийн төрийн байгууллагаас шууд гэрээгээр худалдан авалт хийсэн гэрээ, хэлцэлийн судалгааг улирлаар гаргаж олон нийтэд ил тод болгох.	Улирал тутам	Орон нутгийн өмчийн газар
	3	Иргэд тендерийн үйл ажиллагаа, явц байдлын талаар санал, бодлоо илэрхийлэх, харилцах, гомдол гаргах асуудлыг "Цахим худалдан авах ажиллагааны нэгдсэн систем"-д тусгах		Орон нутгийн өмчийн газар
	4	Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг бүртгэлд хамруулан тухайн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг захиалагч байгууллагаас холбогдох байгууллагад хүргэх тогтолцоог бүрдүүлэх	Жилд	Орон нутгийн өмчийн газар
Зургаа. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
13.(4.1.7.4).Орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах	1	Орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах, хамтран ажиллах	Жилийн турш	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Хууль эрх, зүйн хэлтэс
Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ирэгд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр				
14.(4.1.7.1). Төрийн бодлого боловсруулах, хэлэлэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатнд тухайн		Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг олон нийтэд танилцуулах,	Тухай бүрт	Аймгийн ИТХ-ын

асуудлаар явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авилгатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэн, иргэнийн нийгмийн байгууллагын оролцоог хангах	1	хэлэлцүүлэх, батлагдсан баримт бичгийг цахим хуудас www.bayan-olgi.gov.mn , www.bayan-olgi.khural.mn тогтмол байршуулах, иргэний нийгмийн байгууллагыг танан оролцуулах		ажлын алба, Хууль эрх, зүйн хэлтэс
Найм. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
15.(4.1.10.1).Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	1	Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	Жилд	Хууль эрх зүйн хэлтэс, Сумдын засаг дарга нар
	2	Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэний танхим болон Эрх зүйн туслалцаа үзүүлэх төвтэй хамтран ажиллах	Жилд	Аймгийг ИТХ-ын ажлын алба Хууль эрх зүйн хэлтэс, Сумдын Засаг дарга
	3	Бүх шатны төрийн байгууллагууд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийн үр дүнг сайжруулах	Жилийн эхний улиралд багтаан баталсан байх	Аймгийн Засаг даргын дэргэдэх хэргэжүүлэгч агентлаг, Орон нутгийн өмчит хуулийн этгээд болох "Суат" ХХК, Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газрар

16.(4.1.10.2).Боловсролын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ зохион байгуулах, авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах	1	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын агуулга, хичээлийн хөтөлбөрт шударга ёсны үзэл, хандлагыг бий болгох, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх асуудлыг тусгах	Жилд	Боловсрол, соёл, урлагийн газар
	2	Оюутан, сурагч, эцэг, эхийг хамруулсан шударга ёсны сэдэвт өдөрлөг, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах	Жилд	Боловсрол, соёл, урлагийн газар, Ховд Их Сургуулийн Баян Өлгий аймаг дахь салбар сургууль

-----ooOoo-----